



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 105

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэнээс ирсэн гомдол мэдээллийн дагуу тус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Ар дэнж, Бадайн амны ойн санд мод бэлтгэсэн талбайн асуудлаар тухайн газар нутагт очиж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: Х.Чулуунбат (Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамтгаалалтын захиргааны байгаль хамгаалагч)

Н.Загарзүсэм (Экологийн цагдаа)

Ш.Бумандолгор (Ойн инженер)

М.Мөнхдалай (Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамтгаалалтын захиргааны байгаль хамгаалагч)

Д.Мөнхнасан (Иргэний төлөөлөл)

2.Ар дэнж, Бадайн амны ойн сангийн талбайд мод огтолсон гэх асуудлаар газар дээр нь очиж ажиллан, мэргэжлийн байгууллагууд хууль журмын дагуу ажилласан эсэхийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ж.Нямтогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

